

## ТОВЧ МЭДЭЭ

### ДУХАРЫН БУГАН ХӨШӨӨ

**Ю.БОЛДБААТАР**

*ШУТИС-ийн Түүх-Аялал жуулчлалын баг  
yubo\_9@yahoo.com*

*Түлхүүр үгс: амьтны бодит дүрслэл, хийсвэр дүрслэл, буган хөшөө, Алтай-Саян, Монгол-Өвөр Байгаль, Ховд аймгийн Мөст сум, Бодонч гол*

***ТОВЧ АГУУЛГА:** Ховд аймгийн Мөст сумын Баянхайрхан багийн Духарын голын зүүн эргээс шинээр таван буган хөшөө олов. Тэдгээр нь дүрслэгдсэн зүйлс, ерөнхий хэв шинжээрээ Алтай-Саяны амьтны бодит дүрст буган хөшөөний төрөлд багтах ажээ. Энэхүү товч мэдээгээр Духарын буган хөшөөдийг судлаачдын хүртээл болгож, шинжлэх ухааны эргэлтэнд оруулахыг зорив.*

Судлаач миний бие 2005 оны 9 сарын 22-25-ны өдрүүдэд Ховд аймгийн Мөст сумын Баянхайрхан багийн төвөөс урагш, Бодонч голын хойд эрэг дээрх хүрэл, төмрийн эхэн үеийн буган хөшөөн цогцолборт очиж ажиглалт судалгаа хийсэн юм. Чингэхдээ буган хөшөөний соёлыг цогцлоогч эзэд хөшөөг урлан бүтээж, босгохдоо намрын өдөр, шөнийн тэнцлийг, тодруулбал нарны ургах, шингэхийг хөшөөдийн байрлалаар тэмдэглэн үлдээсэн байж болохыг сонирхсон болно. Тэр үеэр тус багийн иргэн Жамъянгийн Гомбо “Манай зусланд ургаа хад шиг хажуу дээрээ хонхорхойтой уначихсан хөшөөнүүд байдаг” хэмээн мэдээлсний дагуу 9 сарын 24-нд уг нутгийн Ж.Галбадрахаар газарчлуулан Их Улаан даваан дээр гарч баруун хойш нурууны хярыг барьж хэжиж явсаар Духар нуурын бэлчир лүү баруун өмнө зүгээс нь бууж очив. Духар гол нь Монгол Алтайн нурууны Мөнх Хайрхан уулын зүүн урагш үргэлжлэх их нурууны зүүн өмнөөс эх авч Бодонч голд нийлэх богино гол болно.

Духар голын зүүн эрэгт эрт цагт унасан 5 хөшөө байна. Уг хөшөө дурсгал нь Баянзүрх багийн төвөөс баруун хойш 20 гаран км-т хойд өргөргийн 46°38'51", дорнод уртаргийн 92°07'01", далайн түвшнээс 2707м өндөр дэх цэвдэг хөрстэй уулын нугад оршино. Хөшөөний 4 нь Алтай-Саяны амьтны бодит дүрслэлт буган хөшөөний төрөлд хамаарах бөгөөд хоорондоо 1,5-4м-ийн зайтай бөөн оршино. Хөшөөнүүдийн унасан шалтгаан нь голын хөвөөний ус чийгт хөрс, түүний олон жилийн халалт, хөлдөлт зэрэг байгаль цаг уурын үзэгдэл ажээ.

**1-р буган хөшөө:** Зүүн урд талд мөн зүгт газрын гадаргатай 30° хүртэл хазайсан, сууриасаа дээш нарийссан цайвар боржин хөшөө. Баруун хойд талд



хөшөөний хана дагуулан ухсан тарваганы нүх байгаа нь уг дурсгал сууриараа хазайж унахад нөлөөлсөн байж болох. Энэ хөшөө нь бусад хөшөөтэй харьцуулахад дөрвөн талын нэлээд хэсэг нь ил харагдана. Хөшөөний ил хэсгийн нүүрэн талын урт 66 см, арын нуруун талын урт нь 94см, суурь хэсгийн өргөн 30см, орой хэсгийн хавтгай 20x20 см байв. Хөшөөний дээд малгайн хэсэг

нь налуу хавтгайтай хийгээд нүүрэн хэсгийг бодвол харьцангуй хойш, урагш цүлхгэр ажээ. Энэ нь цагирган туузан титмээр шахагдан дээш илүү гарсан үс гэзэг, эсвээс титмийн дотор хэсгээр өмсөгддөг нимгэн малгайн төрөл байж болох юм. Туузан титмийн дорх нүүрэн хэсэгт ташуу 3 зураас, 2 хажуу талд давхар цагирган ээмэг, тэдгээрийн дор хөшөө тойрсон хүзүүний зүүлтний 16 зуйван хонхор байна. Харин хөшөөний арын дунд хэсэгт 18см-ийн голчтой хүрэл толины бүдэгхэн дугуй дүрс байж болох юм.

**2-р буган хөшөө:** Баруун урд байх баруун урагш хазайсаар ихэнх хэсэг нь газар шигдэж булагдсан уг хөшөө нь цайвар саарал боржин чулуугаар хийгдсэн



бөгөөд хөшөөний дээд хэсэгт цагирган туузан титэм, түүний дорх нүүрэн талд ташуу 3 зураас, хажуу талд давхар цагирган ээмэг, хүзүүний зүүлтний 7 зуйван хонхор, харин их биеийн хэсгийн ил харагдах багахан хэсэгт Монгол - Өвөр Байгалийн сонгодог дүрслэлд хамаархуйцаар урлагдсан байж болох хоёр бугын дүрс харагдаж байна. Тэднийг

хөшөөг ороох маягаар урлажээ.

**3-р буган хөшөө:** Хөх саарал өнгийн боржингоор хийгдсэн баруун хойш 60°-т хазайж шигдсэн баруун хойд талд байх уг хөшөөний харагдах хэсгийн урт нь 36 см, өндөр нь 28 см. Дээд хэсэгт цагирган туузан титэм, цагирган ээмэг, хүзүүний зүүлтний 6 зуйван хонхор л ил харагдана.

**4-р буган хөшөө:** Хөх саарал өнгийн боржингоор хийгдсэн баруун хойш хэвтээ байрлалтай, 1-р хөшөөнөөс хойш 4 м, 3-р хөшөөний зүүн талд 1 м-ийн зайд орших уг дурсгалын ил харагдах хэсгийн урт нь 180 см.



Уг хөшөөний толгойд туузан титэм, цагирган ээмэг, хүзүүний зүүлтний 8 зуйван хонхорхой дүрсэлсэн бол харин их биеийн хэсэгт 22 см урт нарийн хошуутай, том нүдтэй нэгэн бугыг хөшөөний уртын дагуу (толгойноос сэрвээ хүртэл 52 см, сэрвээнээс сүүл хүртэл мөн 52 см), орой тийш дүүлж байгаагаар урлан бүтээжээ.

**5-р хөшөө:** Хамгийн хойд талд, голын эрэг дээр оршино. Цагаан цайвар боржингоор хийгдсэн уг хөшөөний ихэнх хэсэг нь булагдсан хийгээд ямар нэгэн мэдэгдэх дүрслэл ажиглагдахгүй байна. Ил харагдах хэсэг нь 40 см, 30 см, 10 см. Дээд оройн хэсэг нь өнгөлсөн мэт тэгш гадаргуутай.

Духарын буган хөшөөнөөс баруун хойш голын цаана 90 м-т нэг, түүнээс цааш 100 м-т бага хэмжээний хоёр хиргисүүр харагдана.

**Дүгнэлт:** Духарын буган хөшөөд нь Алтай-Саяны амьтны бодит дүрслэлт буган хөшөөний төрөлд хамаарах шинээр олдож буй дурсгал болно. Эдгээр нь хөрсний эвдрэл, хөдөлгөөн болоод мэрэгч амьтадаас шалтгаалж шигдэж, унаж булагдсан учир цаашид судлаачид малтаж илрүүлэн бусад дурсгалуудтай харьцуулан судлах хэрэгтэй байна.